

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ.

Энэхүү төлөвлөгөөг “Теем Смайл” ХХК-ийн 2023 онд гүйцэтгэсэн БОННУ-ний нэмэлт тодотгол тайланг үндэслэн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан иргэн, аж ахуйн нэгж тухайн жилд хэрэгжүүлэх “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”- ыг үндэслэн боловсруулав.

1.1. Төслийн товч танилцуулга

Компанийн нэр:

"Налгар түшиг" ХХК Цемент, шохойн үйлдвэр

Улсын бүртгэлийн дугаар: 9019015028

Регистрийн дугаар: 5045924

Компанийн зорилго:

Монгол Улсын MNS974:2008 стандартын шаардлага хангасан OPC42.5 ба PPC32.5 ангийн портланд цементийг 2008 оноос, MNS347-2002 стандартын шаардлага хангасан шохойг 2023 оноос үйлдвэрлэж, барилгын салбарт өсөн нэмэгдэж буй цемент, шохойны хэрэгцээний тодорхой хэсгийг хангах зорилготой.

Үйлдвэрийн байршил:

Улаанбаатар хотын Налайх дүүргийн 4-р хороо, Зэвсэгт хүчний 337-р ангийн нефтийн агуулахын баруун талд 11.7 га талбайг хамарна.

Газарзүйн солбицол:

№	Өргөрөг	Уртраг	Д.Т.Д
1	47°46'37.5"	107°18'42.4"	1419 м
2	47°46'30.3"	107°18'51.6"	1409 м
3	47°46'22.2"	107°18'37.7"	1411 м
4	47°46'27.9"	107°18'29.7"	1419 м

Дэд бүтэц:

Налайх дүүрэг нь УБ хоттой хатуу хучилттай авто зам болон төмөр замаар холбогдсон. Тус үйлдвэр нь дэд бүтэц сайн хөгжсөн бүсэд байрлах ба 1 км зайнаас цахилгааны эх үүсвэрээр хангадаг. Хөдөлгөөнт болон суурин утас, интернет гэх мэт харилцаа холбоо сайн хөгжсөн.

Хүчин чадал:

Цементийн үйлдвэр нь жилд 100.0 мян.тн OPC42.5 ба PPC32.5 ангийн портланд цемент ба 50,000 тн шохой үйлдвэрлэх хүчин чадалтай. Цементийн үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмж нь түүхий эд материалын бутлах хацарт бутлуур, циклон дулаан солилцуулагч бүхий эргэх зуух, түүхий хольц эсвэл шохой, цементийн тээрэм зэрэг болно.

Ажиллах хүч:

Үйлдвэрт байнгын 40 гариу хүн ажилладаг.

Ажилласан хугацаа:

2008 оноос эхлэн тогтвортой үйлдвэрлэлийн үйл ажиллагааг явуулж эхэлсэн ба цаашид тогтмол ажиллана.

Эцсийн бүтээгдэхүүн:

Монгол Улсын MNS974:2008 стандартад нийцсэн цемент байна.

1.2. Төсөлд ашиглаж буй тоног төхөөрөмж

Цементийн үйлдвэр нь жилд 100.0 мян.тн OPC42.5 ба PPC32.5 ангийн портландцемент үйлдвэрлэх төслийн хүчин чадалтай. Цементийн үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжид дараах тоног төхөөрөмжүүд ордог болно. Үүнд:

Хүснэгт-1. Цементийн үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд


Д/Д	Тоног төхөөрөмжийн нэр	Тоног төхөөрөмжийн марк	Тоног төхөөрөмжийн хүчин чадал
1	Хацарт бутлуур	PE400x600	17-40 тн/цаг
2	Бүлт бутлуур	YGP: 700	18-20 тн/цаг
3	Түүхий эдийн тээрэм	Ø=2.2*6.5 м	11-15 тн/цаг
4	Туузан дамжуулагч	L500x40	45 тн/цаг
5	Тоос шүүх фильтр	Ø =2*14 м	200м ³
6	Цахилгаан фильтр	W-113	200м ³
7	Скруббер	No15.5	700 м ³ /цаг
8	Тоос шүүх цахилгаан фильтр	W-113	200м ³
9	Эргэх зуух	W-2835	7.0 тн/цаг
10	Хөргөгч	L 2225	9.0 тн/цаг
11	Нүүрсны тээрэм	1835	5-10 тн/цаг
12	Цементийн тээрэм	Ø=2.2*9 м	10-15 тн/цаг
13	Савлах машин	BGLW	30 тн/цаг

1.3 Төслийн технологи, үйл ажиллагаа:

"Налгар түшиг" ХХК нь хамгийн сүүлийн үеийн технологи болох хуурай аргаар үйлдвэрлэдэг. Хуурай арга нь нойтон аргатай харьцуулахад эдийн засгийн хувьд ашигтай бөгөөд байгаль орчинд бага нөлөөтэй байдаг. Хуурай аргын дутагдалтай тал нь нунтаглах үеийн тоосжилт ихтэй байдаг. Цементийн үйлдвэр нь доорх үе шаттайгаар явагдана. Үүнд:

- ✓ Уурхайгаас түүхий эдийг олборлох, тээвэрлэх
- ✓ Түүхий эдийг бутлах, хатаах
- ✓ Тохиромжтой найрлагатай түүхий хольцыг бэлтгэн тээрэмд нунтаглах
- ✓ Эргэдэг зууханд түлшээр боловсруулалт хийж, хагас боловсруулсан бүтээгдэхүүн буюу клинкер үйлдвэрлэх
- ✓ Клинкериийг хөргөх
- ✓ Клинкериийг гөлтгөнө болон бусад нэмэлтүүдтэй хольж тээрэмдэн нунтаглаж бэлэн бүтээгдэхүүн буюу цемент гарган авах
- ✓ Цементийг хадгалах, савлах

Цементийн үйлдвэрийн технологийн схемийг дараах зурагт харууллаа. “Налгар түшиг” ХХК нь цементийн үйлдвэрийг зөвхөн дулааны улиралд ажиллуулахаар төлөвлөсөн байна.



Зураг-1. Үйлдвэрийн технологийн схем

1.4. Төслийн байгаль орчны ерөнхий төлөв байдал

Улаанбаатар хотын Налайх дүүрэг нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангайн их мужийн Хэнтийн захын өндрийн тойрогт хамаарагдана. Налайх дүүрэг нь засаг захиргааны 7 хороотой. 5 болон 6 дугаар хороод нь жуулчдыг татдаг байгалийн үзэсгэлэнт газар болох Горхи Тэрэлжийн Байгалийн цогцолборт газарт байрладаг. Хоймортоо Майхан уулаа залж, Хатан тунамал Туул гол, Тэрэлжийн голоо зүмбэрлүүлэн, түүх домогт Чингис уул, Суварга хайрхан, Зуун ламын агуй, Арьяабалын сүм хийд, Мэлхий хад, Бүс нуур, Элстэйн зуун мод бүхий үзэсгэлэнт сайхан Налайх нутаг өдгөө ч үйлдвэржилт эрчимтэй хөгжиж буй хот хэвээр байна.

Геологийн тогтоц ба геоморфологи: Цементийн үйлдвэр байрлаж буй Налайхын хотгор нь газарзүйн хувьд Хэнтийн уулархаг нутагт хамаарах бөгөөд Хэнтийн гол ба салбар уулсын бэлийн бэсрэг уулс, ухаа толгодоор хүрээлэгдэнэ. Налайхын хотгор нь 200 км² талбайтай, өргөргийн дагуу бага зэрэг сунаж, урт нь 17-20 км, өргөн нь 10-12 км, умард талаараа өндөр бус уул толгодоор Туул голоор тусгаарлагдах ба уртрагийн чиглэлтэй хэд хэдэн богино хөндий хоолойгоор хэрчигдэнэ. Хотгорын баруун хойд, баруун талаараа Баянзүрх, Богд уулын хааяа бэлийн уулс, өмнөд базүүн талаас нь Буурын даваа, Жанчивлангийн бэсрэг ухаа толгод хүрээлж үндсэндээ битүү хотос гэж болно. Хүрээлэх уулс нь ихээхэн хэрчигдэж бартаа ихтэйгээс гадна уулсын ар хажуу, гуу жалгаар ой мод, бут төгөл ургадаг. Хотгор гүдгэрийн үнэмлэхүй ба харьцах өндөр харилцан адилгүй. Толгодын үнэмлэхүй өндөр 1580-1750 м, хамгийн өндөр цэг нь дэлхийн усны хагалбаруулс болох Богд Хан уул нь 2200 гаруй метр өндөрт өргөгдсөн.

Газар хөдлөлт: Төслийн байршил болон түүний нөлөөллийн бүс дотор газар хөдлөлтийн төвүүд одоогоор бүртгэгдээгүй байгаа боловч уг байршлаас баруун урд зүгт 38-52 км-т Богд хан уулын орчимд 2,5-3,5 баллын хэд хэдэн төвүүд бүртгэгджээ. Энэ хэдийгээр хол мэт боловч газар хөдлөлийн үйлчлэлийн орон зайн цар хүрээг авч үзвэл, төслийн үйл ажиллагаанд нөлөөлнө. Ерөнхий газар чичирхийллийн мужийн хувьд 7 баллын мужид хамаарах бөгөөд энэ нь 10000 жилд нэг удаа тохиолдох магадлалтай.

Хөрсөн бүрхэвч: Налайх орчмын хөрсөн бүрхэвч нь Н.А.Ногина, Д.Доржготов, С.В.Максимович /1984/ нарын ангиллаар Хангайн хөрсний мужийн Дорнод Монголын хөрсөн бүрхэвчийн хошуунд хамаарагдах Хэнтийн өвөр тойрогт багтана. Энэ орчмын хөрсөн бүрхэвчид карбонатлаг хар хүрэн хөрсний хэв шинж зонхилдог бөгөөд ургамлан нөмрөгийн шигүү, сийрэг байдал, хотгор гүдгэрийн онцлогоос шалтгаалан ялзмагт давхаргын зузаан харилцан адилгүй. Дов толгодын орой хэсэгт 2.1-2.4%, жалга судаг дагаж нугажсан өтгөн өвстэй газарт 5-5.4%, дунджаар 3.6%- ийн ялзмагтай байна. Хужир марзархаг ба чулуурхаг хөрс дүүргийн хөндий, уулын бэл хормой, хажуугаар тархалттай. Налайх голын хөндий дагуу намгархаг нуур цөөрөм бүхий хужир, марзархаг талбай тасалдсан зурвас хэлбэрээр тохиолдоно. Хөрсний химийн бохирдолт нь тухайн хөрсөнд ихээхэн хөнөөлтэй дээр экологийн тэнцвэрийг алдагдуулах голлох хүчинзүйлсийн нэг нь болдог юм. Уг район хөрсний бохирдол өндөртэй бөгөөд үүний нөлөөгөөр энэхүү нутгийн байгалийн сэргэлт, нөхөн төлжилт, өөрөө өөрийгөө цэвэрлэх потенциал бага зэрэг буурсан нь экологийн бохирдолт эрчимжихэд хүргэж байна.

Ургамлан нөмрөг: Үйлдвэр барихаар сонгосон газрын байрлал нь Богд хан, Чингис уулын өргөн хотгорын дов, хөндий хосолсон гадаргуутай. Ийм байрлалд ноёлох салхины чиг өвөл зунаар эсрэг тэсрэг байх магадлалтай. Гэвч цаг урын мэргэжилтэн ноёлох салхины чигийг баруун хойд гэсний дагуу судалгааны голлох цэгүүдийг үйлдвэрийн баруунтаа 1, бусдыг Бүс нуурын чигт байрлуулав. Толгой гүвээний оройгоор шивээт хялгана, түүний дааган сүүл-агитай хувилбар, аги бүхий морины ботуул, цахилгана; хөндийгөөр ширгийн улалж, зүлгийн улалж, цахилдаг, түнхэ зонхилно. Нуурын хөвөөгөөр голын цахилдаг, галуун гигэнэ, цэгээлж зэрэг бүлгэмдэл үүсжээ.

Төсөл хэрэгжих талбай болон түүний нөлөөллийн бүсэд хоёр төрлийн ургамалжилт тархсан бөгөөд дийлэнх хувийг хээрийн ургамалжилт эзэлнэ. Хээрийн ургамалжилт – нугажуу хээр, дундаж өндөр ба нам уулсын хялганат, буур өвст, биелэг

өвст (*Stipa baicalensis*, *Festuca sibirica*, *Poa attenuate*, *Filifolium sibiricum*), хянганд хусан төгөл, алаг өвст (*Adenophora 81etanus81e*)

Татмын ургамалжилт – бургаст (*Salix kochiana*, *S.viminalis*), сорвоот (*Calamagrostis purpureum*), улалжит (*Carex cespitosa*, *C.ortostachys*) намаг, алаг өвст (*Thalictrum simplex*) нуга

Хээрийн судалгааны баг бүрэлдэхүүн төсөл хэрэгжиж буй талбай дээр 2022 оны 11 сарын 25-нд ажилласан. Төслийн талбайн ургамалын бичиглэлийг шугам цэгийн бичиглэл хийж талбайн ургамлын зүйлийн бүрэлдэхүүнийг тодорхойлсон ба рамескийн тор ашиглан мөн ургамлын бичиглэл, зүйлийн эзлэх хувь болон халцгай газрын эзлэх хувь зэргийг уг судалгаагаараа тодорхойлсон.

Судалгааны үр дүнгээс үзэхэд төслийн талбайн ургамлын нөмрөгийн тархац 30-40%, агь, гашуу, ерхөг, хазаар, дэрс, таана, хөмүүл, хялгана голлон ургана. Ургамлын хэв шинжийн хувьд сийрэг ургамалтай чулуурхаг бэлчээрийн хэв шинжэд хамаардаг бөгөөд ургамлын зүйлийн бүрдэл 3-4 /хазаар өвс, таана, хялгана, аммоны сэдэргэнэ, гуу жалгаар алтан харгана/ зүйлийн ургамал тархсан эх газрын чулуулаг ил гарсан таана-хялганат бүлгэмдлийн хэв шинжийг харуулсан талбай байна.

1.5. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Тус үйлдвэрийн үйл ажиллагааны улмаас хүрээлэн буй орчинд учрах болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, дүгнэлт, урьд өмнө хийгдсэн байгаль, нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгааны материалууд, судалгаа явуулсан мэргэжлийн экспертүүдийн дүгнэлтүүдийг үндэслэн тодорхойлов. Тус үйлдвэрийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөлөлд өртөгдөх байгалийн үндсэн тусгагдахуун нь агаар, хөрс, газрын гадарга, ургамал, амьтан юм.

Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг тогтоох зорилгоор шинжээчдийн хэсэг газар дээр нь очиж, Үйлдвэрийн хэрэгжилтийн байдал болон орчны байдалтай танилцаж холбогдох судалгааг хийсэн болно.

Гол сөрөг нөлөөлөл:

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллүүдээс агаар орчны бохирдол, хөрсны бохирдол, хүний эрүүл мэнд нь гол сөрөг нөлөөлөлд өртөгч объект болох нь судалгаагаар тогтоогдож байна. Голлох нөлөөллийг тодруулахад дараах зүйлүүдийг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагаанаас (бохирдлын) түвшинг тодорхойлох
- ✓ Үйлдвэрийн альтернатив хувилбаруудыг зааж өгөх
- ✓ Нөлөөллийн үр дагаврыг бууруулах арга замыг тодорхойлох

Үйлдвэрийн үйл ажиллагааны гол сөрөг нөлөөллийн хэмжээ, тархалт, үр дагавар нь харилцан адилгүй байна.

Төслийн боломжит нөлөөллийн тодорхойлолт:

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх нөлөөллийн бүсийг урьдчилсан байдлаар тогтоохдоо БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан нөлөөлөл буурах функцийг ашигласан болно. Зурагт нөлөөлөл буурах функц ашиглан нөлөөллийн эрчим, орон зай, цаг хугацааны тархалтыг зураглалаа. Төслийн талбайгаас 1 км-т нөлөөллийн эрчим хүчтэй, 3км-т нөлөөллийн эрчим дунд 5 км-т аажмаар буурч байна. БОНХСайдын А/117 тоот аргачлалд заасан үзүүлэлтээр байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 2. Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
1	Газрын гадаргын хэв шинжэд гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	

4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	+	
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх	+	
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн одис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх		-
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		-
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	
Орчны бохирдол			
10	Төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа төрлийн бохирдуулагч болон аюултай, хортой бодис агаар мандалд ялгарах эсэх	+	
11	Дуу шуугианы нөлөө	+	
12	Чичиргээний нөлөө	+	
13	Дулааны нөлөө	+	
14	Цахилгаан соронзон долгионы нөлөө	+	
15	Цацрагийн нөлөө		-
16	Гадаргын болон газрын доорх усанд бохирдуулагч бодис нэвчих үед		-
Эрсдэлийн үнэлгээ			
17	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
18	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	
Нийгэм эдийн засаг			
19	Төслийн хэрэгжилттэй холбоотой нийгэмд тодорхой өөрчлөлт гарах эсэх	+	
20	Хүн амын амьжиргааны түвшин өөрчлөгдөх	+	
21	Бизнесийн таатай орчин бүрэлдэх	+	
22	Орон нутгийн төсвийн орлого нэмэгдэх	+	
23	Шинээр ажлын байр бий болох	+	
24	Орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх	+	
25	Хөдөлмөр эрхлэлтэд өөрчлөлт гарах	+	
26	Тухайн орон нутгийн оршин суугчдын зан үйл, шашин шүтлэгт сөргөөр нөлөөлөх		-
27	Тухайн орон нутгийн оршин суугчдын дасан зохицсон амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх	+	
28	Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, тухайн үед орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх	+	
29	Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх	+	

Дээрх байгаль орчны шинжилгээний үр дүнг үндэслэн байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн эх үүсвэр болон нөлөөлөлд өртөгдөх байгаль орчин, нийгэм эдийн засгийн бүрэлдэхүүн хэсгийг тодорхойлохдоо “Магадлан жагсаах арга”-ыг ашиглав. НҮБХХБ болон Байгаль орчин аялал жуулчлалын яамны хамтран хэрэгжүүлж буй Монгол улсын Байгаль орчны засаглалыг бэхжүүлэх нь төслийн хүрээнд боловсруулсан аргачлалд заасан магадлан жагсаах аргын хувилбарыг нөлөөллийн эх үүсвэр, тэдгээрт өртөгдөх байгаль, нийгэм, эдийн засгийн хам бүрдлийг тодорхойлоход ашигласан болно.

Төслийн байршил, шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

“Цемент шохойн” үйлдвэрлэлийн үйл ажиллагааны үед уг Төслийн байршил, техник технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлан жагсаалтад түүний нөлөөллийн үр дагаврыг “бага”, “дунд”, “их” гэсэн утгуудын аль тохирохыг “+” гэж бөглөв.

Барилга байгууламж барих, үйлдвэрийн аюулгүй ажиллагаатай хологдож гарах байгаль орчны асуудал: Тус Төслийн тээвэрлэлт, тээврийн хэрэгсэл, дүрэм журмыг мөрдөөгүй тохиолдолд хөрс, бохирдох эрсдэлтэй. Үйлдвэрлэлийн осол аваараас сэргийлэх, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж байх шаардлагатай болно. Мөн ахуйн хог хаягдлыг зөөх, далдлах, ариутгах зэрэг ажлыг тодорхой хуваарийн дагуу хийж, халдварт өвчин гарахаас урьдчилан сэргийлж байх нь зүйтэй.

“Цемент шохойн” үйлдвэрлэлийн төслийн үйл ажиллагаанаас байгалийн хам бүрдэлд үзүүлэх нөлөөллийг эрэмбэлбэл жижиг хөхтөн амьтад, тэдгээрийн амьдрах орчин хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, геоморфологийн хэлбэршил, агаарын чанар, усны нөөц, горим орж байна. Төслийн үйл ажиллагааг эрэмбэлбэл хамгийн их нөлөөлөл үзүүлэх хүчин зүйл нь олборлолтын үйл ажиллагаа гадаад овоолго юм. Мөн дотоод замаар тээвэрлэлт хийх нь гол нөлөөлөл юм. Бусад хүчин зүйл нь Төслийн төлөвлөлт, удирдлага зохион байгуулалтыг холбогдох стандартын дагуу хийж гүйцэтгэх нөхцөлд хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөлөл харьцангуй бага байх боломжтой юм.

Хүснэгт 3. Төслийн байршил шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл

№	Байгаль орчны асуудлууд	Нөлөөлөл байхгүй	Гол үр дагавар		
			Бага	Дунд	Их
1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал					
1.1	Голын голдиролгүй эвдэж өөрчлөх	+			
1.2	Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал	+			
1.3	Ой модыг огтлох, гэмтээх	+			
1.4	Түүх соёлын дурсгалт газар, археологи-паленотлогийн олдвор газрыг эвдэхэд хүрэх	+			
1.5	Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх	+			
1.6	Булаг, шанд усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх	+			
2. Төслийн шийдэл төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал					
2.1	Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, олборлох технологи, орчны хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой			+	
2.2	Үйлдвэрлэлийн осол мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн			+	

2.3	төслөгөөс гарах крунтын уснаас хамгаалах, хорт бодис нэгдлээс хамгаалах асуудал хир нийцтэй тусгагдсан үр ашигтай ажиллах явдал хир зэрэг зохимжтой.	+			
2.4	Тоосжилт дарахад ашиглах технологийн шийдэл	+			
2.5	Төслийн үйл ажиллагааны үед гарах дуу чимээг багасгах талаар төсөлд тусгагдсан эсэх			+	
3. Барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн аюулгүй ажиллагаатай холбогдож байгаль орчны асуудал					
3.1	Барилга байгууламж барих үед усны нөөц бохирдох байдал	+			
3.2	Барилга байгууламж барих үеийн болон барьсны дараах хөрсний элэгдэл эвдрэл			+	
3.3	Үйлдвэрлэлийн осол аваар гарах нөхцөл			+	
3.4	Хортой нөхцөл үүсэх		+		
3.5	Халдварт өвчин гарах нөхцөл		+		
4. Төслийг ерөнхийд нь хянаж үзэх шалгуурууд					
4.1	Төслийг хэрэгжүүлэх явцад байгалийн бусад нөөц баялгийг ашиглах боломжийг алдах			+	
4.2	Төслийн техник технологийн шийдлийг техник эдийн засгийн хувьд олон хувилбараас авч үзэн аль болох оновчтой аргыг сонгосон эсэх		+		

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

2.1. Байгаль орчны менежментийн 2025 оны төлөвлөгөөний тухай

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд үүсэж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

“Налгар түшиг” ХХК нь Байгаль орчинд ээлтэй эерэг талаас нь боловсруулсан ба шаардлагатай хөрөнгө мөнгө, зардлыг 2025 оны төсөвт тусгаж, төлөвлөгөөг цаашид саадгүй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлсэн юм.

Байгаль орчин хамгаалах төлөвлөгөө

Хууль зүйн үндэс:

Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Хог хаягдлын тухай”, “Галын аюулгүй байдлын тухай”, “Барилгын тухай”, “Ариун цэврийн тухай”, “Стандартчилал, Хохирлын үнэлгээний тухай” хуулиуд болон Засгийн Газар, Байгаль орчны болон бусад холбогдох яамнаас гаргасан заавар журмын дагуу байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөг боловсруулав. Энэхүү төлөвлөгөөнд цементийн үйлдвэрийн байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх бүхий л арга хэмжээг тусгасан байна.

Байгаль орчин, техник технологийн асуудал:

Үндсэн үйл ажиллагаа нь Налайх дүүргийн 4-р хороонд цемент үйлдвэрлэж, барилгын компани, аж ахуйн нэгж байгууллагуудад борлуулах явдал юм. Цементийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг хадгалах, зайлуулах, арилгах, тээвэрлэх ба ангилсан хог хаягдлыг дахин боловсруулалтанд өгөх, орчны бохирдлыг багасгах, гал түймэр гарах эрсдлийг бууруулах, цемент үйлдвэрлэх техник технологийн үйл явцаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, бусад аюул, осол, эрсдэлээс сэргийлэх арга технологийг 2023 оны нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайланд тусгагдсаныг үндэслэн төлөвлөгөөг боловсруулсан.

Байгаль орчин-нийгэм эдийн засгийн асуудал:

Тус компани нь 40 гариу хүн ажлын байраар хангаж, тэдгээрийн нийгмийн асуудал цогцоор шийдэж ажиллахын зэрэгцээгээр дүүргийн төсөвт жил бүр 0,8-1,0 тэрбум төгрөгийн татвар төлдөг үндэсний үйлдвэрлэгч юм. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу үйлдвэрийн байршлын газрыг нөхөн сэргээх, ургамлан бүрхэвчийг хамгаалах, байгаль орчныг хамгаалах бүх зардлыг “Налгар Түшиг” ХХК өөрийнхөө үйл ажиллагааны зардалд тусгасан болно.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт:

Байгаль орчныг хамгаалах зохион байгуулалт, төлөвлөлт болон үйлдвэрийн орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийг “Налгар Түшиг” ХХК бүрэн хариуцан гүйцэтгэн ажиллахын зэрэгцээ төлөвлөгөөний биелэлтийг удирдлагын хүрээнд авч үзэж, хэлэлцэн шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь шийдвэрлэж байх болно

2.2. Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ

“Налгар түшиг” ХХК нь үйл ажиллагаа явуулж буй явцад тогтоогдсон төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, түүнээс урьдчилан сэргийлэх, үр дагаврыг арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, зарцуулах төсөв, баримтлах эрх зүйн баримт бичиг зэргийг нэгтгэж доорх хүснэгтэд тусгалаа.

Хүснэгт 4 Сөрөг нөлөөллийг бууруулах менежментийн төлөвлөгөө ба зардал

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамаарах хүрээ	Төсөвлөсөн зардал, сая.төг	Баримтлах стандарт, эрх зүйн орчин
АГААРЫН ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ				
Тээврийн хэрэгслийн утаа агаар орчныг бохирдуулах	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг тогтмол шалгах	Тээврийн хэрэгслийн эд ангиуд	Үйл ажиллагааны зардлаар	MNS 4585:2016” “Гадаад орчны агаарын түгээмэл бохирдуулагчийн хүлцэх агууламж болон зөвшөөрөгдөх түвшин стандарт MNS 5877 : 2008 Гол замын ба сэлгээний илчит тэрэгний ялгаруулах хорт бодис болон ажилласан хийн утаажилт. Норм хэмжээ ба тодорхойлох арга MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 5002:2000
Тоосорхог ачаа ачих, буулгах үед тоос үүсэх	Түүхий эд материал буулгах үед үүсэх тоосыг тодорхой хэмээнд усалгаа хийж дарах.		ОХШХ-ийн зардлаар	
	Агаарын бохирдлын /CO, SO2, NO2, Тоос/ шинжилгээ хийлгэж байх		ОХШХ-ийн зардлаар	
Төслийн талбайд ахуйн хог хаягдлын сав, бохир ус дамжуулах хоолой болон бохир ус цуглуулах хэсгийн битүүмжлэл муу байснаас үнэрийн бохирдол үүсэх	Хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж тухай бүрт нь хогийн цэгт хаях, ариутгах, хогийн цэгийг хлорын шохойн 5-10%-ийн уусмалаар ариутгаж байх		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тусгасан зардлаар	
ХӨРСӨН БҮРХЭВЧИНД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ				
Барилгын ажлын үе шат, автомашины хөдөлгөөн зэргээс хөрс элэгдэл, эвдрэл үүсэхээс гадна хог хаягдал, бохирын шингэн алдагдсанаас хөрсөнд бохирдол үүсэж болзошгүй.	Автомашины зогсоол, зам талбайг тэмдэгжүүлэх	Төслийн талбайн зам талбай	Үйл ажиллагааны зардлаар	MNS3297:1991. Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм MNS5850:2019. Хөрсний чанар, хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5850:2008 Хөрсний чанар, Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
	Төслийн объектууд хооронд явган хүний зам тавих (өнгөт хавтан, чулуу, хөндий банзан г.м),	Төслийн талбайн зам талбай	Үйл ажиллагааны зардлаар	
	Стандартын шаардлага хангасан бохир усны цооног, бие засах газар бий болгох	Төслийн талбай	Ү.а-ны зардлаар	
	Тоосжилтыг багасгаж шороон замыг хатуу хучилттай болгох	Төслийн талбайн зам талбай	Ү.а-ны зардлаар	

УРГАМЛАН БҮРХЭВЧИД ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ				
Зонхилох ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, талхагдал өөрчлөлт	Төслийн төлөвлөгөөнд тусгагдсан талбайд мод, бут сөөг тарьж, орчны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Төслийн талбай	Үйл ажиллагааны зардлаар	-
	Ургамлын мониторингийн цэг байгуулан жил бүр тогтмол мониторинг хийх	Төслийн талбай	ОХШХ-ийн зардлаар	
АМЬТНЫ АЙМАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ				
Төслийн үйл ажиллагаанаас бий болох хог хаягдлыг эмх замбараагүй хаяснаар амьтдын амьдрах орчин бохирдох, зарим зүйл амьтан хордох	Хог хаягдлыг түр цуглуулах цэг бий болгох Төслийн талбайн ойр орчмын хог хаягдлыг тогтмол цэвэрлэх	Төслийн талбай	Ү.а-ны зардлаар	-
Цахилгаан дамжуулах агаарын шугам хоорондын шонд зэрлэг шувууд тогонд цохиулах	Цахилгаан дамжуулах агаарын шугам хоорондын шон бүрт зэрлэг шувуу үргээх төхөөрөмж байршуулах, хамгаалалтаар бүрэх	Төслийн талбай	Ү.а-ны зардлаар	-
Нийт			Үйл ажиллагааны зардлаар	-

2.3. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Төслийн талбайд ачиж, буулгах үйл ажиллагаа явуулах тул тоос шороо босох, агаарт тоосжилт үүсэх тул сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж төслийн талбайд МУ-ын Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн дагуу нийт эдэлбэр газрын 30%-тай тэнцэх талбайд ногоон байгууламж байгуулахыг зорин ажиллаж байна. Тус төслийн үйл ажиллагаа, орчин нөхцөлийг харгалзан төслийн талбайд арц, улиас, монос зэрэг ургамал тарьж байна.Тухайлбал, улиас түргэн ургадаг, үзэмжтэй, гоё үнэр ялгаруулдаг, мөн тоос шороо, дуу чимээг шингээх чадвартай зэргээс шалтгаалан түлхүү тарихаар төлөвлөж байна.

Хүснэгт 5 Суулгацын төрөл, үнэ

Нэр	Талбайн урт,м	Мод хоорондын зай, м	Эгнээ хоорондын зай, м	Нэг суулгацын үнэ, ₮	Тарьц, ш	Нийт үнэ, ₮
Бүйлс	200	3	2	3500	67	234.500
Хайлаас	200	3	3	5500	67	335.000
Чацаргана	200	3	2	5000	66	330.500
Бүгд					200	900.000

Тайлбар: Мод хооронд 3 м, эгнээ хооронд 4 м зайтай суулгана. Тарьсан суулгацыг нэг эгнээнд оруулж тооцвол суулгац хооронд 1 м зайтай байх болно. Үндэсний урт 30-35 см-аас доошгүй, гол ишний уг 4-5 см-аас багагүй бүдүүн, 1.0-2.0 м өндөр, 3-4 настай суулгацыг шилжүүлэн суулгахаар төлөвлөж байна.

2.4 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Тус төслийн талбайд одоогоор түүх, соёлын өв илрээгүй. Тус төслийн үйл ажиллагааны явцад археологи, палеонтологийн олдвор, түүх соёлын дурсгалт зүйлс илэрвэл үйл ажиллагаагаа түр зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх ба цаашид Монгол улсын “Соёлын өвийг хамгаалах тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг мөрдөн ажиллах шаардлагатай.

2.5. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Энэхүү төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг тусгалаа.

Хүснэгт 6 Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйн баримт бичиг,стандарт аргачлал
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө				
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник,технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай барилг байгууламжинд	0,4	Гамшгаас хамгаалах тухай хууль, Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Бүх ажилчдад	0,2	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	0,3	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох сумын байгаль орчны алба, байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Үйл ажиллагааны турш	Ү.а-ны зардлаар	
	Химийн бодисын эрсдэл бусад осол аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөний зардал	Үйл ажиллагааны турш	4,6	
Нийт дүн сая.төг			5,5	

2.6. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Нийт зардал, сая.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Төслийн хүрээнд	0.2	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2	Хатуу хог хаягдлыг цуглуулж нэгдсэн цэгт - хүргэж устгаж байх	Төслийн хүрээнд	0.5	
3	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, аль болох олон газарт байрлуулах	Төслийн хүрээнд	0,1	
4	Хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, зайлуулах, дахин ашиглах тогтолцоог нэвтрүүлэх	Төслийн хүрээнд	Ү.а-ны зардлаар	
5	Шингэн хаягдлыг гэрээний нөхцлөөр цаг тухай бүр соруулан зайлуулах	Төслийн хүрээнд	0,2	
6	Бохирын цооногийн орчны ариутгал халваргүйжүүлэлтийг цаг тухайд нь хийх	Төслийн хүрээнд	0,5	
	Нийт, сая төгрөг		1,5	

2.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Тус төслийн 2025 оны орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, байгаль хамгаалах төлөвлөгөөнд тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, дээж авах цэг байршил, хугацаа давтамж, баримтлах зарим гол стандарт, аргачлал, зардлыг тайлбарын хамт тусгав.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөр төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, төсөл хэрэгжих орчинд амьдардаг, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамж зэргийг бүхэлд нь тусгасан.

Тухайн төслийг хэрэгжүүлснээс үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэж нэрлэдэг.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой гэж үзсэн.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Налгар түшиг” ХХК хариуцах болно.

Хүснэгт 8 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналт шинжилгээ хийх байршил	Нийт зардал мян.төг	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
Агаарын чанар, дуу чимээ				
1	Агаарын бохирдлын (NO2, SO2, PM2.5, PM10) шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбай болон орчны бүсэд	350,0	MNS5885:2008 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага
2	Дуу шуугиан, чичиргээ: Хүнд даацын машины тээврийн зам, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн орчим		250.0	
Хөрсний бохирдол				
3	Хөрсний морфологи бичиглэл, рН, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент (NO3, P2O5, K2O), хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устөрөгчийн нэгдлүүд, кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайр	Төслийн талбай	300.0	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ; MNS 5850:2008 Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Ургамал, амьтан				
4	Ургамал, амьтны мониторинг хийх	Төслийн талбайн эргэн тойронд	372.0	Биологийн хүрээлэнгийн баталсан арга зүй, Ажиглах бүртгэх
Нийт			1.272.0 мян.төг	

2.9. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Хүснэгт 9 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Нийт зардал /сая.төг/
Удирдлага зохион байгуулах	
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	Үйл ажиллагааны зардлаар
Газрын төлөв байдал, хянан баталгаа хийлгэх /2021 онд хийгдсэн/	-
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	Үйл ажиллагааны зардлаар
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	Үйл ажиллагааны зардлаар
Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын тайланг БОАЖГ-т хүргэн өгч байх	-
Тусгай зөвшөөрөлтэй талбайд газрын төлөв байдлын чанарын улсын хянан баталгааг хуулиар тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагаар хийлгэж байх	-
Байгаль орчны хамгаалах тухай хуулийн 10 ¹ дүгээр зүйлд заасны дагуу Байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх	Үйл ажиллагааны зардлаар
Нийт зардал	Үйл ажиллагааны зардлаар

2.10. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Налгар түшиг ХХК нь жил бүр Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллагад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлдэг. Мөн төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн иргэдийн хуралд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар танилцуулгыг жил тутамд хийхээр төлөвлөж байна.

Хүснэгт 10 Оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агууллага	Хугацааны тов	Хэлэлцүүлэгээр санал авах	Зохион байгуулах газар
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах					
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Налайх дүүргийн 4-р хорооны засаг захиргааны байгууллагад танилцуулж, хэлэлцүүлнэ.	БОМТ-ний биелэлтийн тайлан боловсруулж сумдын засаг захиргаанд хүргүүлнэ.	БОМТ-ний биелэлт	БОМТ-ний хэрэгжилтийн явцад орон нутгийн засаг захиргааны байгууллагууд болон оршин суугчдад танилцуулна.	Дүүргийн засаг захиргааны удирдлага болон байгаль орчны байгууллагын санал, шүүмжийг хүлээн авч шийдвэрлэх	Налайх дүүргийн 4-р хорооны сумын захиргааны байр
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Налайх дүүргийн 4-р хорооны оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах			Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	

2025 оны БОМТ-нд тусгасан нийт зардал

Хүснэгт 11 2025 оны БОМТ-ний нийт зардал

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арилгах арга хэмжээ	Үйл ажиллагааны зардлаар
2	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	900,0
3	Түүх, соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө	-
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	5500,0
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1500,0
6	Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр	1272,0
7	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	Үйл ажиллагааны зардлаар
	Нийт /БОМТ-ний 2025 оны/ зардал	9172,0

Нийт 9,172,000 /Есөн сая нэг зуун далан хоёр мянга/ төгрөг болно.

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ хуулийн 9.10-д Ашигт малтмалын ашиглалт, баяжуулах, боловсруулах үйлдвэр, химийн үйлдвэрийн үйл ажиллагааны төсөл хэрэгжүүлэгч нь байгаль орчныг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх баталгаа болгож, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нөхөн сэргээлтийн тусгай данс буюу **100900013406** тоот **БО нөхөн сэргээх баталгаа** дансад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө буюу **4,586,000 төгрөг** тушааж байршуулав. Баримтыг хавсаргав.

Жич: Төлбөрийн 2 хувааж 2025-03-14-ны өдөр 2,783,000 төгрөг, 2025-06-26-ны өдөр 1,803,000 төгрөгөөр тус тус байршуулсан болно.


Огноо/Date: 2025-03-14 10:12:19

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information

Журналын /Journal No: 5676499

Гүйлгээний дугаар /PoId: 1065456159

Системийн огноо/System Date: 2025-03-14 10:12:01

Дт	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Rate
	5077345666	НАЛГАРТУШИГ	2,783,000.00 MNT	1.00
Кт	Банкны дугаар/Branch No МОНУМНУВ	Банкны нэр/Bank Name ТӨРИЙН САН	2,783,000.00 MNT	1.00
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа		
	MN780090 100900013406			

Гүйлгээний утга/Transaction description:

БВ-НӨХӨН СЭРГЭЭЛТ БАРЬЦАА 5045924

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэр/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

11:32 M

4G 78



Шилжүүлгийн баримт/ Transaction receipt



noreply@khanbank.com

khanbank.com

To: NALGARTUSHIG@YAHOO.COM

11:27



Огноо/Date:2025.06.26 11:27:10

Шилжүүлгийн мэдээлэл/Transaction information
Журналын/Journal No:001185381064

Системийн огноо/System Date:2025.06.26 11:27:10

Дт/ From	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card number	Нэр/Name	Дүн/Amount	Ханш/Ra te
	5077345666	НАЛГАР ТҮШИГ ХХК	1,803,000.00 MNT	1.00
/ Нэг сая найман зуун гурван мянган төгрөг /				
Кт/ To	Банкны дугаар/Branch No 90	Банкны нэр/Bank Name State Fund - Төрийн Сан		
	IBAN/Дансны/Картын дугаар IBAN/Account/Card Number MN780090100900013406	Нэр/Name БО нөхөн сэргээх баталгаа	1,803,000.00 MNT	1.00

Гүйлгээний утга/Transaction description:
ЕВ-Нөхөн сэргээлтийн барьцаа 5045924

Харилцагч танд баярлалаа./Thank you to our customers

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан/Transaction statement verified:

Салбар, тооцооны төв/Branch, sub-branch:

Гарын үсэг/Signature:

Тамга/Stamp:

_____ Он/Year (YYYY) _____ Cap/Month (MM) _____ Өдөр/Day (DD)

Сурталчилгаа/Advertisement:



khanbank

Visit site



Delete



Reply



Reply all



Forward



More



**НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД,
ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЭЛЭЛ**

- ~ Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайнтөслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- ~ Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “*хамааралгүй*” гэж бөглөнө.
- ~ 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн нөхөн сэргээсэн газрыгбэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
1.1	1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн нэр	“Налгар түшиг” ХХК
	2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн дугаар	9019015028
	3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэл	Цемент үйлдвэрлэх
	4. Аж ахуйн нэгжийн харъяаллын хаяг	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 2-р хороо, Их найман шарга төв, 5 давхарт
	5. Захирлын нэр, утас, цахим шуудангийн хаяг	Ерөнхий захирал: Ж.Батбаяр утас:99115635, nalgartushig@yahoo.com
	6. Холбогдох мэргэжилтний нэр, утас, цахим шуудангийн хаяг	О. Адъяа Утас: 99108745
1.2	1. Төслийн нэр	“Портланд цементийн үйлдвэр”
	2. Төслийн харъяаллын байршил	Улаанбаатар хотын Налайх дүүргийн 4-р хороо, Зэвсэгт хүчний 337-р ангийн нефтийн агуулахын баруун талд 11,7 га талбайг хамрана.
	3. Төслийн ангилал	Цементийн үйлдвэр
	4. Төсөл эхэлсэн огноо	2008 оноос үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн
	5. Төсөл хэрэгжих хугацаа	
	6. Үйлдвэрийг хүлээж авсан улсын комиссын дүгнэлт	2009 оны 10 сарын 09 – ны өдөр “Налгартүшиг” ХХК-ны мэдэлд ашиглалтад оруулж үйлдвэрлэл явуулахыг зөвшөөрсөн улсын комиссын акт гарсан байна.
	7. ТЭЗҮ баталсан огноо	2007
	8. 2024 оны бүтээгдэхүүний нийт хэмжээ /дундаж/	19347 мян тн цемент үйлдвэрлэсэн.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

- ~ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэнхуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- ~ Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- ~ Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл Дугаар Хүчинтэй хугацаа Талбай	МУ 123-006/22 2027 оны 03-р сарын 15 хүртэл хүчинтэй. 117000 м ²
2.2	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах, тэсрэх дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн дагуу олгосон холбогдох зөвшөөрөл бусад баримт бичиг/ Дугаар Хүчинтэй хугацаа	Хангалттай 0001603 2023-03-31
2.3	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын дүгнэлт	Хангалттай
2.4	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	2025-10-22 №0017990
2.5	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	БОНБНҮ-ний нэмэлт тодотголыг 2023 онд хийж БОАЖЯ-аар батлуулсан.
2.6	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо	2023
2.7	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	2024-04-29
2.8	8. Тухайн жилийн батлагдсан үйлдвэрлэлийн төлөвлөгөөний огноо	-
2.9	9. Тухайн жилд баримтлаж ажиллах стандартын дугаар: Үндэсний: Олон улсын:	MNS976:2008 MNS3091:2008

ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- ~ Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсан тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах
- ~ Тухайн жилд химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/
- ~ Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “**хангалттай**” гэсэн дүгнэлтийг оруулна.
 - урьдчилан сэргийлэх арга хэмжээ
 - эрсдлийн үед авах арга хэмжээ
 - учруулсан хор уршгийг зайлуулах, бууруулах арга хэмжээ
 - хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ
- ~ Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/ химийн бодис, бүтээгдэхүүнээс гарах сав баглаа боодлын хэмжээ	Хавсралт
	2. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	Хангалттай
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх 2. Тэсрэх, дэлбэрэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	20 тн багтаамжтай дизель, түлшний нөөцлөх савтай.
3.3	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/ • Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ • Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ • Аюултай хог хаягдал	Ахуйн хатуу, шингэн хог хаягдал : Жилд 9360 кг хатуу хог хаягдал гарна. Жилд 12 удаа тээвэрлэж зайлуулна. Ахуйн шингэн хог хаягдал: Жилд 314,4 м ³ шингэн хог хаягдал үүсч, 32 удаа тээвэрлэн зайлуулна. Үйлдвэрийн хатуу хог хаягдал: Төслийн үйл ажиллагаанаас жилд дунджаар 30 тн хатуу хог хаягдал үүсэх ба жилд 8 удаа тээвэрлэнэ.
	2. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Тухайн жилийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх нийт төсвийг дотоод зардлаар шийдвэрлэнэ.

**ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

Доорх хүснэгтийн 4.12 - 4.1.7 –д тусгагдсан тухайн жилийн арга хэмжээний төсвийн нийлбэр нь 4.1.1 –д тусгагдана.

Д/ Д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
4.1	1. Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв	9172,0 мян төгрөг
	2. Нөлөөллийг зайлуулах арга хэмжээний төсөв /технологийн зөв шийдэл/	Дотоод зардал
	3. Нөлөөллийг бууруулах арга хэмжээний төсөв	Дотоод зардал
	4. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төсөв	Хамааралгүй
	5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төсөв	Дотоод зардал
	6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний төсөв	Дотоод зардал
	7. Тухайн жилийн орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн нийт төсөв	1272,0 мян, төгрөг.

ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

- ~ Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.
- ~ Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл	
	1. Ажилчдын байр, оффис	+
	2. Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлуулагч гэх мэт)	+
	3. Хог хаягдлын цэгийн байршил	+
	4. Хог хаягдлын агуулахын байршил	+
	5. Хог хаягдлын далан	+
	6. Химийн бодисын агуулахын байршил	+
	7. Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил	+
	8. Гүний худгийн байршил	+
	9. Дүйцүүлэн хамгааллын байршил	+

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГА ХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ
НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

- ~ Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүншинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “**тодорхойлсон**”, “**тодорхойлоогүй**” “**хамааралгүй**” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.
- ~ Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

Нөлөөллийн ангилал	А. Тооц он эсэх	Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлс он эсэх	В. Нөлөөллийн эрчмийг тодорхойлс он эсэх	Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх	Дүгнэлт
6.1.Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Нөөцийг бууруулах	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг бууруулах	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	Хамааралгүй	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	Тодорхойлсон	Тодорхойлсон	Тодорхойлоогүй	Тодорхойлоогүй	

ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

- ~ Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх
- ~ Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “**тийм**”, “**үгүй**” хариулт өгнө.
- ~ Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнүүд “**хангалттай**” “**хангалтгүй**” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	А. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Хамааралгүй	Үгүй	Үгүй	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	36	Тийм	Тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ - техникийн/ га эзэлхүүн - биологийн /га	Хамааралгүй	Үгүй	Үгүй	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	Хамааралгүй	Үгүй	Үгүй	
7.5 Төслийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах арга хэмжээ	4	Тийм	Тийм	

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЯНАЛТЫН ХУУДАС**

- ~ Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “**А, Б, В, Г**” багананд байгальхамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв
Хөрс	1	4	1	300,0 мян, төгрөг
Ургамал, амьтан	1	2	1	372,0 мян, төгрөг
Хөрс	2	2	1	300,0 мян, төгрөг
Агаар	8	8	1	350,0 мян, төгрөг

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг: О.Адъяа

/2025 он 03 сар 13 өдөр /

